



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.5, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын Баянхонгор, Хэнтий аймгийн Автотээврийн төвийн салбаруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн, нийт 35,000,000.00 (гучин таван сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын Баянхонгор аймгийн Автотээврийн төвийн дарга С.Амармөнх, Хэнтий аймгийн Автотээврийн төвийн дарга Б.Ганбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр орлогод авах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 730, 768 дугаар тогтоолыг тус тус хүчингүйд тооцсугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
133001268

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны
өдрийн 05 дугаар тогтоолын хавсралт



**"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) |
|-----|---|--------------------------|--------------------------------|-------------------------|
| 1 | Тоёото маркийн, 00-10 ХЭУ улсын дугаартай, суудлын автомашин, хөдөлгүүрийн дугаар- HDJ810051532 | 22,000,000.00 | 22,000,000.00 | |
| 2 | Ниссан маркийн, 00-77 БНХ улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар- NT30028294 | 13,000,000.00 | 13,000,000.00 | |
| | | 35,000,000.00 | 35,000,000.00 | |
| | Нийт дүн | (гучин таван сая) | (гучин таван сая) | |